

Аудитын код: САГ-2018/02/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	2
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	3
2.9.1.	Авлагын талаар :	3
2.9.2.	Дуусаагүй үйлдвэрлэл дансны талаар:	4
2.9.3.	Орлого төвлөрүүлэлтийн талаар:	4
2.9.4.	Өглөгийн талаар:	4
2.9.5.	Бүртгэл тайлагналын талаар:	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
2.16	Үр өгөөжийн талаар	6
3	Менежментийн захидал.....	7
3.1.	Авлагын талаар.....	8
3.2.	Өглөгийн талаар	9
3.3.	Орлого төвлөрүүлэлтийн талаар.....	10
4.	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1.	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2.	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3.	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4.	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.5.	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХАРИЛЦАА ХОЛБОО,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.ЧИНБАТ
ТАНАА

2018. 03.23 № 06/812
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0323SAG35.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071416

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг ХХМТГ-ын дарга Б.Чинбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас орлогыг бүрэн төвлөрүүлэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 20-ноос 2018 оны 3 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 24-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор О.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 6/196-дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт 2018 оны 3 дүгээр сарын 9-ны өдөр ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

БНҮҮС-ийн эрхэм зорилго нь “Монгол улсын нутаг дэвсгэрт зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох зорилгоор төрийн бодлогын хүрээнд мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хамгийн түгээмэл үйлчилгээг тухайн хүн амын байршил, амьжиргааны түвшингээс үл хамааран бодит үнээр хүргэх, алслагдсан орон нутагт зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх, сүлжээг шинээр барьж байгуулах, өргөтгөх, үйлчилгээ явуулах” явдал гэж тодорхойлсон байна.

Энэхүү зорилгыг хангаж ажиллахын тулд Харилцаа холбооны тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Засгийн газрын 2009 оны 151 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам”-д нийцүүлэн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтууд дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж ирсэн байна.

Тайлант онд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас хөдөлгөөнт холбооны чиглэлээр 3, Интернетийн үйлчилгээг хүргэх чиглэлээр 2, радио, телевизийн үйлчилгээний чиглэлээр 1, шуудангийн чиглэлээр 1, судалгаа, сурталчилгааны чиглэлээр 3, нийт 8 төсөл хэрэгжүүлсэн байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.


Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 12 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “asolous” программ хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлан бодох дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа



гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тайлант онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод алба нь БНҮҮС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийсэн байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд төсвийн зардлын нийт гүйцэтгэл 4,291.6 сая төгрөг буюу 88.7 хувьтай байна. Гүйцэтгэлээр нийт зардлын 48.7 хувь буюу 2,091.4 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт, 43.2 хувь буюу 1,855.0 сая төгрөгийг тайлант онд харилцаа, холбоо, шуудангийн чиглэлээр хэрэгжсэн төсөл хөтөлбөрт, 4.6 хувь буюу 198.0 сая төгрөгийг өмнөх онуудад хэрэгжүүлсэн төслийн үлдэгдэлд, 3.5 хувь буюу 147.2 сая төгрөгийг урсгал зардалд тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 139.1 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь шилэн дансанд байршуулах мэдээллээ Шилэн данс нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn> цахим хуудсанд бүх мэдээллээ хуульд заасан хугацаанд мэдээлсэн байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдэлийг 8 чиглэлээр тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1. Авлагын талаар :

Шуудангийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий 52 байгууллагын БНҮҮС-д төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолоор баталсантай холбоотой байгууллагуудын авлага шууд үүссэн нь авлагын тооцоо нийлж баталгаажуулахгүй байх шалтгаан болсон байна. Уг шалтгааны улмаас тооцоо нийлж баталгаажуулаагүй 95.2 сая төгрөгийн авлага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 04 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шуудангийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай авлагын тооцоо нийлж баталгаажуулах, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах зөвлөмж өгөх,



2.9.2. Дуусаагүй үйлдвэрлэл дансны талаар:

1) Дуусаагүй үйлдвэрлэл данснаас өмнөх онуудад хэрэгжиж дууссан 6,911.4 сая төгрөгийн төслийг хасч тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан нь тайлант оны үр дүнд нөлөөлсөн,

2) Тайлант онд дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй судалгаа, сурталчилгааны чанартай 3 төслийг бүрэн хэрэгжүүлж дууссан боловч уг төслүүдийн зардлын 142.0 сая төгрөгөөр дуусаагүй үйлдвэрлэл дансны хаалтын бичилт хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", УСНББОУС 1-ийн 27-д: "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй өмнөх онуудад хэрэгжиж дууссан төслийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан, мөн тайлант онд судалгаа, сурталчилгааны чанартай 3 төслийг бүрэн хэрэгжүүлж дууссан төслүүдийн зардлын дүнгээр дуусаагүй үйлдвэрлэл дансны хаалтын бичилт хийгдээгүй зэрэг 7,053.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

2.9.3. Орлого төвлөрүүлэлтийн талаар:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 463 байгууллагаас улсын төсөвт 2,192.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,052.9 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 139.1 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", МТШХХГ-ын даргын 2013 оны 107 дугаар тушаалаар батлагдсан БНҮҮС-ийн үйл ажиллагааны дүрмийн 8.1-д "МТШХХГ-нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын дагуу хяналт тавьж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөний дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас орлогыг бүрэн төвлөрүүлэх зөвлөмж өгөх.

2.9.4. Өглөгийн талаар:

Санхүүгийн байдлын тайлан болон өглөгийн тодруулга тайланд тусгасан 5.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл хэдэн онд анх үүссэн, хэнд өгөх нь тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах зөвлөмж өгөх.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.9.5. Бүртгэл тайлагналын талаар:

Тайлант хугацааны Санхүүгийн үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үлдэгдэл, 2016 оны жилийн эцсийн аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан 0.6 сая төгрөг, Мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдлээс 637.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", мөн хуулийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", УСНББОУС 1-ийн 27-д: "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 638.4 сая төгрөгийн алдааг залруулав.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7,931.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 7,691.9 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 239.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,033.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг 59.6 хувь, 14,268.5 сая төгрөгийн алдааг залруулах 4 зөвлөмжийг 83.0 хувьтай тус тус биелүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,154.4 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 91.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн "Зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа."



2.16 Үр өгөөжийн талаар

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар урьдчилсан байдлаар нийт 7,696.8 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэсэн болно.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1. АВЛАГЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Шуудангийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий 52 байгууллагын БНҮҮС-д төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолоор баталсантай холбоотой байгууллагуудын авлага шууд үүссэн нь авлагын тооцоо нийлж баталгаажуулахгүй байх шалтгаан болсон байна. Уг шалтгааны улмаас тооцоо нийлж баталгаажуулаагүй 95.1 сая төгрөгийн авлага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 04 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулиудын холбогдох заалтууд зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Шуудангийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай авлагын тооцоо нийлж баталгаажуулах,

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2. Өглөгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
-----------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн байдлын тайлан болон өглөгийн тодруулга тайланд тусгасан 5.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл хэдэн онд анх үүссэн, хэнд өгөх нь тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулиудын холбогдох заалтууд зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3. Орлого төвлөрүүлэлтийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №3
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 463 байгууллагаас улсын төсөвт 2,192.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,052.9 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 139.1 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, МТШХХГ-ын даргын 2013 оны 107 дугаар тушаалаар батлагдсан БНҮҮС-ийн үйл ажиллагааны дүрмийн 8.1-д “МТШХХГ-нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмын дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төлөвлөгөөний дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас орлогыг бүрэн төвлөрүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**4.1. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,462,373,838.21	10,316,108,203.35
МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,975,001.01	9,975,001.01
Банкинд байгаа бэлэн мөнгө	9,975,001.01	9,975,001.01
Төрийн сангийн харилцах	9,975,001.01	9,975,001.01
АВЛАГА	2,226,197,963.20	2,073,531,938.34
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,192,445,987.20	1,192,445,987.20
Бусад авлага	1,033,751,976.00	881,085,951.14
Байгууллагаас авах авлага	1,033,751,976.00	881,085,951.14
БАРАА МАТЕРИАЛ	13,226,200,874.00	8,232,601,264.00
Дуусаагүй үйлдвэрлэл	13,226,200,874.00	8,232,601,264.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22,074,495.16	20,296,661.96
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,074,495.16	20,296,661.96
Биет хөрөнгө	21,199,495.29	19,588,328.77
Авто-тээврийн хэрэгсэл	57,380,895.00	34,600,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(45,904,716.16)	(20,677,618.98)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,517,543.31	24,517,543.31
Хуримтлагдсан элэгдэл	(18,647,425.78)	(21,278,953.53)
Тавилга, аж ахуйн эд хогшил	11,732,563.54	11,732,563.54
Хуримтлагдсан элэгдэл	(7,879,364.62)	(9,305,205.57)
Биет бус хөрөнгө	874,999.87	708,333.19
Програм хангамж	4,150,000.00	4,150,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(3,275,000.13)	(3,441,666.81)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,484,448,333.37</u>	<u>10,336,404,865.31</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,020,162.60	11,972,538.60
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,020,162.60	11,972,538.60
Өглөг	5,020,162.60	11,972,538.60
Бусад өглөг	-	84,576.00
Хувь хүмүүст төлөх өглөг	-	84,576.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,479,428,170.77	10,324,432,326.71
Засгийн газрын хувь оролцоо	15,479,428,170.77	10,324,432,326.71
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,761,977,619.52	15,761,977,619.52
Өмч: - төрийн	15,761,977,619.52	15,761,977,619.52
Хуримтлагдсан үр дүн	(290,151,568.40)	(5,445,147,412.46)
Өмнөх үеийн үр дүн	(2,088,390,413.08)	(7,201,566,578.40)
Тайлант үеийн үр дүн	1,798,238,844.68	1,756,419,165.94
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,602,119.65	7,602,119.65
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>15,484,448,333.37</u>	<u>10,336,404,865.31</u>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,541,777,043.21	4,151,546,360.99
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,382,328,322.21	2,098,633,953.52
Нийтлэг татварын бус орлого	2,382,328,322.21	2,098,633,953.52
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,382,328,322.21	2,098,633,953.52
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,382,028,322.21	2,082,981,572.52
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	15,652,381.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,159,448,721.00	2,052,912,407.47
Улсын төвлөрсөн төсвөөс	2,159,448,721.00	2,052,912,407.47
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,159,448,721.00	2,052,912,407.47
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,743,538,198.53	2,386,520,060.99
УРСГАЛ ЗАРДАЛ	683,419,603.67	298,120,787.61
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	683,419,603.67	298,120,787.61
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,711,599.46	107,758,285.47
Үндсэн цалин	88,319,600.00	100,440,185.47
Унаа хоолны хөнгөлөлт	7,391,999.46	7,318,100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,813,200.00	11,853,500.00
Тэтгэврийн даатгал	7,895,993.45	11,853,500.00
Тэтгэмжийн даатгал	383,441.30	00.00
ҮОМШӨ-ний даатгал	479,301.65	00.00
Ажилгүйдлийн даатгал	95,860.30	00.00
Эрүүл мэндийн даатгал	958,603.30	00.00
Хангамж, бараа материалын зардал	16,192,398.22	10,977,500.00
Бичиг хэрэг	1,996,080.00	1,823,750.00
Тээвэр, шатахуун	10,258,000.00	5,372,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,176,151.22	1,380,851.38
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,762,167.00	2,400,898.62
Эд хогшил, урсгал засварын зардал	7,600,967.00	5,929,992.00
Багаж, техник, хэрэгсэл	840,597.00	5,929,992.00
Урсгал засвар	6,760,370.00	00.00
Томилолт, зочны зардал	9,141,180.00	7,070,500.00
Дотоод албан томилолт	8,141,180.00	6,390,500.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,000,000.00	680,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	811,730.00	816,430.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	495,000.00
Даатгалын үйлчилгээ	115,830.00	115,830.00
Тээврийн хэрэгслийн татвар	165,900.00	183,600.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	544,148,328.99	153,714,580.14
Бараа үйлчилгээний бусад зардал	530,128,200.30	00.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,350,000.00	2,821,500.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,670,328.99	8,823,080.14

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,060,118,594.86	2,088,399,273.38
Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	00.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,200,000.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,058,918,594.86	2,088,399,273.38
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,058,918,594.86	2,088,399,273.38
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,798,238,844.68</u>	<u>1,765,026,300.00</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	8,607,134.06
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	8,607,134.06
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-8,607,134.06
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,798,238,844.68</u>	<u>1,756,419,165.94</u>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.3. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	-290,151,568.40	15,479,428,170.77
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	-290,151,568.40	15,479,428,170.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-6,911,415,010.00	-6,911,415,010.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	-7,201,566,578.40	8,568,013,160.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,756,419,165.94	1,756,419,165.94
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,761,977,619.52	7,602,119.65	-5,445,147,412.46	10,324,432,326.71

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ

САНАЛ ДҮГНЭЛТ

4.4. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,368,852,169.54	4,288,644,580.85
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,207,563,919.54	2,235,647,597.38
Нийтлэг татварын бус орлого	2,207,563,919.54	2,235,647,597.38
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,207,563,919.54	2,235,647,597.38
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,207,263,919.54	2,235,647,597.38
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,161,288,250.00	2,052,996,983.47
Улсын төвлөрсөн төсвөөс	2,159,448,721.00	2,052,912,407.47
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,159,448,721.00	2,052,912,407.47
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,839,529.00	84,576.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,839,529.00	84,576.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,386,345,749.54	4,288,644,580.85
УРСГАЛ ЗАРДАЛ	4,386,345,749.54	4,288,644,580.85
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,451,764.68	147,227,707.47
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,711,599.46	107,758,285.47
Үндсэн цалин	89,561,718.32	100,440,185.47
Унаа хоолны хөнгөлөлт	6,149,881.14	7,318,100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,813,200.00	11,853,500.00
Тэтгэврийн даатгал	9,813,200.00	11,853,500.00
Хангамж, бараа материалын зардал	16,088,398.22	10,977,500.00
Бичиг хэрэг	1,892,080.00	1,823,750.00
Тээвэр, шатахуун	10,258,000.00	5,372,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,176,151.22	1,380,851.38
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,762,167.00	2,400,898.62
Эд хогшил, урсгал засварын зардал	11,235,657.00	5,929,992.00
Багаж, техник, хэрэгсэл	4,475,287.00	5,929,992.00
Урсгал засвар	6,760,370.00	
Томилолт, зочны зардал	9,141,180.00	7,070,500.00
Дотоод албан томилолт	8,141,180.00	6,390,500.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,000,000.00	680,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	811,730.00	816,430.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	495,000.00
Даатгалын үйлчилгээ	115,830.00	115,830.00
Тээврийн хэрэгслийн татвар	165,900.00	183,600.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,650,000.00	2,821,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,350,000.00	2,821,500.00
ТАТААС	2,159,448,721.00	2,053,017,600.00
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,159,448,721.00	2,053,017,600.00
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,159,448,721.00	2,053,017,600.00

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,079,445,263.86	2,088,399,273.38
Бусад урсгал шилжүүлэг	3,039,529.00	00.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,839,529.00	00.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,200,000.00	00.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,076,405,734.86	2,088,399,273.38
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,058,918,594.86	2,088,399,273.38
Хөрөнгийн	17,487,140.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-17,493,580.00</u>	<u>00.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-17,493,580.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,468,581.01	9,975,001.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,975,001.01	9,975,001.01

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,839,332,900.00	4,291,637,176.88	547,695,723.12	88.68
УРСГАЛ ЗАРДАЛ	4,839,332,900.00	4,291,637,176.88	547,695,723.12	88.68
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,332,900.00	147,227,707.50	105,192.50	99.93
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,759,100.00	107,758,285.50	814.50	100.00
Үндсэн цалин	100,441,000.00	100,440,185.50	814.50	
Унаа хоолны хөнгөлөлт	7,318,100.00	7,318,100.00	-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,853,500.00	11,853,500.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	1,077,600.00	11,853,500.00	(10,775,900.00)	
Тэтгэмжийн даатгал	7,543,100.00	-	7,543,100.00	
ҮОМШӨ-ний даатгал	862,100.00	-	862,100.00	
Ажилгүйдлийн даатгал	215,500.00	-	215,500.00	
Эрүүл мэндийн даатгал	2,155,200.00	-	2,155,200.00	
Хангамж, бараа материалын зардал	10,977,500.00	10,977,500.00	-	100.00
Бичиг хэрэг	1,871,100.00	1,823,750.00	47,350.00	
Тээвэр, шатахуун	5,205,800.00	5,372,000.00	(166,200.00)	
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,600.00	1,380,851.38	539,748.62	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,980,000.00	2,400,898.62	(420,898.62)	
Эд хогшил, урсгал засварын зардал	5,930,100.00	5,929,992.00	108.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	5,930,100.00	5,929,992.00	108.00	
Томилолт, зочны зардал	7,070,500.00	7,070,500.00	-	100.00
Дотоод албан томилолт	5,813,200.00	6,390,500.00	(577,300.00)	
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	680,000.00	577,300.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	920,700.00	816,430.00	104,270.00	88.67
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,000.00	495,000.00	-	
Даатгалын үйлчилгээ	198,000.00	115,830.00	82,170.00	
Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	183,600.00	14,400.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	22,000.00	7,700.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	2,821,500.00	2,821,500.00	-	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,821,500.00	2,821,500.00	-	
ТАТААС	2,192,000,000.00	2,053,017,600.00	138,982,400.00	93.66
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,192,000,000.00	2,053,017,600.00	138,982,400.00	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,192,000,000.00	2,053,017,600.00	138,982,400.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000,000.00	2,091,391,869.38	408,608,130.62	83.66
Засгийн газрын шилжүүлэг	2,500,000,000.00	2,088,399,273.38	411,600,726.62	83.54
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,500,000,000.00	2,088,399,273.38	411,600,726.62	

Бусад урсгал шилжүүлэг	-	2,992,596.00	(2,992,596.00)	
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	2,992,596.00	(2,992,596.00)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,192,000,000.00	4,291,637,176.85	(2,099,637,176.85)	195.79
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,192,000,000.00	2,052,912,407.47	139,087,592.53	93.65
Улсын төсвөөс санхүүжих	2,192,000,000.00	2,052,912,407.47	139,087,592.53	
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	3,077,172.00	(3,077,172.00)	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	3,077,172.00	(3,077,172.00)	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,235,647,597.38	(2,235,647,597.38)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,235,647,597.38	(2,235,647,597.38)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,975,001.01		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,975,001.01		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	10	10		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**